

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Төрийн тусгай албан хаагчдын нэгдсэн эмнэлгийн
2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: САГ-2026/217/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:
www.audit.mn

Улаанбаатар хот

2026 он

Санхүүгийн аудитын газрын захирал,
тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг
Утас: 261663 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn

Аудитын менежер Б.Долгорсүрэн
Утас: 261885 Цахим хаяг: dolgorsuren@audit.gov.mn

Ахлах аудитор П.Амарсанаа
Утас: 261740 Цахим хаяг: amarsanaap@audit.gov.mn

Аудитор Н.Нямсүрэн
Утас: 261740 Цахим хаяг: nyamsuren@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ	6
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА	13
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа	13
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин	13
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	13
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд	14
3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв	15
4. АУДИТЫН ТАЙЛАН	17
4.1 Ерөнхий зүйл	17
4.2 Материаллаг байдал	17
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	17
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	17
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт.....	18
4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд	18
4.5 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн.....	19
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	19
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	21
5.1 Албан шаардлага	21
5.2 Зөвлөмж.....	21
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ	23

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
БНКУ	Бүгд найрамдах Казахстан улс
МН	Маш нууц
ОХУ	Оросын холбооны улс
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
ХБНГУ	Холбооны Бүгд найрамдах Герман улс
ХЗДХС	Хууль зүй, дотоод хэргийн сайд
ХХОАТ	Хувь хүний орлогын албан татвар
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
ЭМДС	Эрүүл мэндийн даатгалын сан



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

Засгийн газрын IV байр, Бага тойруу 3,
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160
Утас: 26 04 37, Факс: (976-51) 26 42 30,
Цахим шуудан: info@audit.gov.mn,
Цахим хуудас: www.audit.mn

2026.02.25 № 06/315
танай _____-ны № _____-т

ТӨРИЙН ТУСГАЙ АЛБАН ХААГЧДЫН
НЭГДСЭН ЭМНЭЛГИЙН ЗАХИРЛЫН
АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ Т.НАРАНТУЯА ТАНАА

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Төрийн тусгай албан хаагчдын нэгдсэн эмнэлгийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/ өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний үзэж байгаагаар Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл хэсэгт тайлбарласан зүйлсийн үр нөлөөг эс тооцвол 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу бүхий л материаллаг байдлын үүднээс үнэн зөв толилуулсан байна.

Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу хараат бусаар гүйцэтгэж, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно. Тухайлбал:

- Эмнэлгийн үйл ажиллагаанд ашигладаг эрүүл мэндийн программ нийлүүлэгч компанийг сольж, нууцын үйл ажиллагаа явуулах зөвшөөрөлгүй компани сонгон шалгаруулж, “Эмнэлгийн тусламж үйлчилгээний цахим программ ашиглуулах, хөгжүүлэлт хийх гэрээ” байгуулж, төрийн болон албаны нууц, иргэн, өвчтөний эмзэг мэдээллийг ашиглуулсан, өвчний түүхийг цаасан хэлбэрээр хөтөлсөн, өвчтөний мэдээлэл устсан зэрэг ноцтой эрсдэлүүд үүсгэж, тус программтай холбоотой 46,063.0 мянган төгрөг зарцуулсан;
- Эрүүл мэндийн даатгалын сангаас авах хасагдлын дүн өмнөх оноос 132,414.9 мянган төгрөгөөр өссөн;
- Өмгөөллийн үйлчилгээнд 16,700.0 мянган төгрөг зарцуулж, үр ашиггүй зардал гаргасан.

Дээрх зөрчлүүд нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс даваагүй боловч шинж чанарын хувьд санхүүгийн тайланд материаллаг нөлөөтэй боловч өргөн тархаагүй байна.

Энэ нь Төрийн болон албаны нууцын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3-т "төрийн болон албаны нууц тээгч" гэж төрийн болон албаны нууцыг бичвэр, тэмдэг, дүрс, дохио, техникийн шийдэл, үйл ажиллагааны хэлбэрээр агуулж байгаа материаллаг зүйлийг", 12 дугаар зүйлийн 12.1.8-д "төрийн нууцтай танилцах албан тушаалтан, иргэнд аюулгүй байдлын шалгалт явуулах, төрийн болон албаны нууцыг ашиглан үйл ажиллагаа явуулах, ажил гүйцэтгэх хуулийн этгээдийг судалж, шалгах", Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.3-т "Мэдээллийг энэ хуульд заасны дагуу олж мэдсэн этгээд бусдад задруулахыг хориглоно", Засгийн газрын "Журам батлах тухай" 2017 оны 246 дугаар тогтоолын 4.6.1-т "Хуулийн этгээдэд нууцад хамаарах мэдээлэл ашиглан үйл ажиллагаа явуулах, ажил гүйцэтгэх (цаашид "нууц үйл ажиллагаа явуулах" гэх) эрхийг Төрийн болон албаны нууцын тухай хууль болон энэхүү журамд заасны дагуу тагнуулын байгууллага олгоно", 4.6.2-т "тагнуулын байгууллага тухайн хуулийн этгээд нууц үйл ажиллагаа явуулах зохих нөхцөл, шаардлагыг хангасан болохыг баталгаажуулж энэхүү журмын 2 дугаар хавсралтаар баталсан Маягт 5-д заасан Аюулгүй байдлын гэрчилгээг олгоно", Төрийн болон албаны нууцын тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.3, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4, Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1, 16 дугаар зүйлийн 16.5.2, 16.5.5 дахь заалтуудтай нийцээгүй бөгөөд санхүүгийн тайлагналын нийцсэн бөгөөд зохистой байх, иж бүрэн байх, эрх ба үүрэг батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Асуудлыг онцолсон хэсэг

Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2024 оны А/110 дугаар тушаалаар баталсан "Хамгийн чухал нь" эрүүл мэндийн эрт илрүүлэг, тандалт, эрүүл мэндийн боловсрол олгох зорилтот арга хэмжээний хүрээнд 2025 оны 5 дугаар сарын 31 хүртэлх хугацаанд нийт 20 аймгийн 13000 гаруй алба хаагч, тэдгээрийн гэр бүлд 7 ээлжийн 70 гаруй эмч, мэргэжилтнүүд Шүүх шинжилгээний ерөнхий газрын сэтгэл зүйчдийн бүрэлдэхүүнтэй хамтран эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлж, Сайдын эрхлэх асуудлын хүрээний 11 агентлаг, байгууллагын алба хаагчдын эрүүл мэндийн эрсдэл, тэргүүлэх өвчлөлийг тодорхойлж, II шатны эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлж, тайлант онд 327,712.3 мянган төгрөгийг зарцуулсан байна.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

ТӨБЗГ-ын 2025 оны "Үндсэн хөрөнгө шилжүүлэн бүртгэх зөвшөөрөл олгох тухай" А-1/2635 дугаар албан бичгийн дагуу Хууль зүй, дотоод хэргийн яамнаас 3,699,000.0 мянган төгрөгийн үнэ бүхий Соронзон резонанст томограф (mri) аппаратыг балансаас балансад шилжүүлэн авч, ТӨБЗГ-ын 276 дугаар тогтоолоор 3,421,624.8 мянган төгрөгийн балансын үнэ бүхий хөрөнгийг акталж, данснаас хассан байна.

Төрийн тусгай албан хаагчийн нэгдсэн эмнэлэг нь Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2025 оны А/08 дугаар тушаалаар баталсан "Худалдан авах ажиллагааны 2025 оны төлөвлөгөө"-нд нийт 8,223,592.1 мянган төгрөгийн төлөвлөгөө батлуулж, 6 дугаар сард 1,206,850.0 мянган төгрөгөөр нэмж, 9,430,442.1 мянган төгрөг болгон тодотгосон боловч төлөвлөлт хангалтгүй байгаагаас гүйцэтгэл, нийт 5,768,669.8 мянган төгрөг буюу 61.3 хувийн биелэлттэй байна.

Хууль зүй, дотоод хэргийн сайдын болон эмнэлгийн захирлын тушаал, шийдвэрээр баталсан Төрийн болон албаны нууцын жагсаалтад батлаагүй байхад эмнэлгийн бүтэц, орон тоо, албан тушаалын ангилал, зэрэглэлийг нууцалж, төрийн аудитын байгууллагад ирүүлснээс аудитын горим, сорил гүйцэтгэх боломжгүй болсон.

Бусад асуудал

Төрийн тусгай албан хаагчдын нэгдсэн эмнэлэг эрүүл мэндийн тусламж үйлчилгээндээ чанарын менежментийн тогтолцоо ISO 9001:2015 олон улсын стандартыг амжилттай нэвтрүүлэн хэрэгжүүлсэн бөгөөд хөндлөнгийн аудитад амжилттай хамрагдаж, БНКУ-д төвтэй Олон улсын магадлан итгэмжлэлийн ACQH байгууллагын 460 шалгуур үзүүлэлтийг хангаж, Олон улсад магадлан итгэмжлэгдсэн анхны төрийн өмчийн эмнэлэг болжээ.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР *В. М.* ЦНАРАНЧИМЭГ



2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Код	Дансны нэр, төрөл	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	11,926,985,704.78	5,964,397,149.96
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	1,906,690,209.18	119,550,547.03
31200	Банкинд байгаа бэлэн мөнгө	1,906,690,209.18	119,550,547.03
31210	Төгрөг	1,906,690,209.18	119,550,547.03
31211	Төрийн сангийн харилцах	1,906,680,209.18	119,550,547.03
31213	Арилжааны банк дахь харилцах	10,000	зөвлөмж -
33	АВЛАГА	5,078,627,627.16	1,416,138,039.32
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	205,785.08	-
33300	Татаас, санхүүжилтийн авлага	3,520,000.00	1,092,989.59
33500	Бусад авлага	5,074,901,842.08	1,415,045,049.73
33510	Байгууллагаас авах авлага	5,074,901,842.08	1,415,045,049.73
35	БАРАА МАТЕРИАЛ	4,941,667,868.44	4,428,708,563.61
35100	Түүхий эд материал	2,099,569,787.79	1,471,363,304.17
35130	Эм боох материал	2,099,569,787.79	1,471,363,304.17
35300	Бэлэн бүтээгдэхүүн	1,023,079,468.30	1,002,687,337.19
35400	Хангамжийн материал	1,812,787,612.35	1,949,462,922.25
35410	Бичиг хэргийн материал	51,295,225.60	28,560,272.30
35420	Аж ахуйн материал	18,885,780.00	29,267,860.00
35430	Сэлбэг хэрэгсэл	720,219,913.00	809,887,336.50
35440	Түлш, шатах тослох материал	9,694,261.59	5,303,772.28
35450	Барилгын засварын материал	15,784,100.00	17,624,200.00
35460	Хүнсний материал	39,819,614.00	44,878,659.00
35470	Бусад хангамжийн материал	957,088,718.16	1,013,940,822.17
35600	Мал амьтад	6,231,000.00	5,195,000.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	30,171,240,759.90	30,579,858,519.92
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	30,171,240,759.90	30,579,858,519.92
39200	Биет хөрөнгө	29,836,939,713.63	30,295,565,145.48
39201	Барилга, байгууламж, орон сууц	19,422,727,731.00	21,659,311,147.14
39202	Хуримтлагдсан элэгдэл	(2,297,204,597.61)	(4,464,315,605.39)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	473,594,265.10	332,211,256.20
39204	Хуримтлагдсан элэгдэл	(403,210,931.44)	(147,661,581.16)
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	31,416,644,941.74	31,857,086,693.23
39206	Хуримтлагдсан элэгдэл	(20,054,380,468.30)	(19,434,096,435.26)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	1,179,064,117.94	1,167,654,928.92
39208	Хуримтлагдсан элэгдэл	(705,059,136.31)	(677,956,791.53)
39209	Зам, гүүрийн байгууламж	83,151,248.00	3,388,000.00
39210	Хуримтлагдсан элэгдэл	(21,731,299.22)	(56,466.67)
39214	Бусад үндсэн хөрөнгө	2,245,694,495.04	-
39215	Хуримтлагдсан элэгдэл	(1,502,350,652.31)	-
39300	Биет бус хөрөнгө	334,301,046.27	284,293,374.44
39301	Програм хангамж	338,374,037.00	318,377,057.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(249,614,990.73)	(279,625,682.56)
39303	Бусад биет бус хөрөнгө	245,542,000.00	245,542,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН 3=1+2	42,098,226,464.68	36,544,255,669.88
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	1,570,400,368.75	873,869,360.04
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	1,570,400,368.75	873,869,360.04
41300	Өглөг	1,570,400,368.75	873,869,360.04
41340	Хөрөнгө бэлтгэхтэй холбогдсон өглөг	152,740,968.15	93,415,885.90
41360	Бусад өглөг	1,417,659,400.60	780,453,474.14
41361	Байгууллагад төлөх өглөг	1,417,659,400.60	780,453,474.14
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	40,527,826,095.93	35,670,386,309.84
51	Засгийн газрын хувь оролцоо	40,527,826,095.93	35,670,386,309.84
51100	Засгийн газрын оруулсан капитал	238,499,530.00	238,499,530.00

511001	Улсын төсвийн оруулсан хөрөнгө	238,499,530.00	238,499,530.00
51200	Хуримтлагдсан үр дүн	40,289,326,565.93	35,431,886,779.84
51210	Өмнөх үеийн үр дүн	39,526,620,230.97	40,289,326,565.94
51220	Тайлант үеийн үр дүн	762,706,334.96	(4,857,439,786.10)
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН 6=4+5	42,098,226,464.68	36,544,255,669.88

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Код	Дансны нэр, төрөл	Өмнөх он	Тайлант он
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН	27,392,063,832.13	24,807,275,269.15
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	2,707,638,259.13	24,807,275,269.15
120	Нийтлэг татварын бус орлого	2,707,638,259.13	6,672,883,546.15
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	2,222,296,651.20	1,947,296,752.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,774,083,937.98	1,934,465,252.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	59,432,228.00	12,831,500.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	388,780,485.22	-
120009	Бусад орлого	15,306,251.05	-
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	447,749,415.00	4,678,631,723.67
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	22,285,941.88	46,955,070.48
122	Тусламжийн орлого	-	18,134,391,723.00
1221	Хандив тусламж /дотоод/	-	18,134,391,723.00
12211	Харьяа төрийн сангаас төсвийн байгууллагад олгосон санхүүжилт, шилжүүлгийн орлого	-	5,299,980,000.00
122111	Урсгал санхүүжилтийн орлого\	-	5,299,980,000.00
122001	Бусад хандив тусламж /дотоод/	-	12,834,411,723.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	24,684,425,573.00	-
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	9,772,100,000.00	-
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	9,772,100,000.00	-
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	14,912,325,573.00	-
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	14,912,325,573.00	-
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	26,615,177,756.92	29,664,715,055.25
21	УРСГАЛ ЗАРДАЛ	26,615,177,756.92	29,664,715,055.25
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	26,395,603,710.59	28,763,146,683.71
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	13,481,101,582.12	14,735,697,134.82
210101	Үндсэн цалин	7,144,635,120.72	7,766,735,928.45
210102	Нэмэгдэл	4,245,636,099.95	5,163,557,656.61
210103	Унаа хоолны хөнгөлөлт	578,154,000.00	835,108,000.00
210104	Урамшуулал	1,512,676,361.45	970,295,549.76
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	999,499,661.22	1,048,118,878.56
210201	Тэтгэврийн даатгалын зардал	599,291,641.90	610,646,222.88
210202	Тэтгэмжийн даатгалын зардал	70,731,057.29	73,573,959.95
210203	ҮОМШӨ-ний даатгалын зардал	34,553,728.97	40,130,139.33
210204	Ажилгүйдлийн даатгалын зардал	32,849,060.46	34,045,000.93
210205	Эрүүл мэндийн даатгалын зардал	262,074,172.60	289,723,555.47
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	523,515,756.32	588,495,186.96
210301	Гэрэл, цахилгаан	275,036,964.58	364,725,057.23
210302	Түлш, халаалт	93,052,787.85	87,567,053.75
210303	Цэвэр, бохир ус	155,426,003.89	136,203,075.98
2104	Хангамж, бараа материалын зардал	448,908,023.93	394,608,107.38

210401	Бичиг хэрэг	13,924,320.40	17,577,821.30
210402	Тээвэр, шатахуун	25,338,237.01	17,865,724.31
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	33,450,889.22	34,067,701.77
210404	Ном, хэвлэл	3,636,940.00	393,750.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	63,854,004.00	44,342,084.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	265,377,603.30	238,325,180.00
210408	Бараа материал акталсны зардал	43,326,030.00	42,035,846.00
2105	Нормативт зардал	5,410,300,657.25	6,451,598,339.51
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	4,642,156,858.28	5,761,771,488.82
210502	Хоол, хүнс	704,429,304.30	599,240,135.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	63,714,494.67	90,586,715.69
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	555,463,608.00	265,979,252.50
210601	Багаж, техник, хэрэгсэл	336,187,428.00	23,313,187.50
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	63,380.00	-
210604	Урсгал засвар	219,212,800.00	242,666,065.00
2107	Томилолт, зочны зардал	33,624,325.00	69,140,000.00
210701	Гадаад албан томилолт	17,374,325.00	4,000,000.00
210702	Дотоод албан томилолт	14,860,000.00	64,140,000.00
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	1,390,000.00	1,000,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	456,226,728.00	322,937,442.33
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	245,523,166.00	187,931,278.33
210803	Даатгалын үйлчилгээ	5,712,000.00	7,639,136.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	329,652.00	1,106,656.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	-	99,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	175,077,500.00	86,402,000.00
210807	Газрын төлбөр	1,448,790.00	1,533,790.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	105,400.00	-
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	28,030,220.00	38,225,582.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	4,486,963,368.75	4,886,572,341.65
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	59,791,261.00	46,344,640.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	34,558,360.00	43,307,175.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	4,392,613,747.75	4,796,920,526.65
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	219,574,046.33	901,568,371.54
2132	Бусад урсгал шилжүүлэг	219,574,046.33	901,568,371.54
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	155,327,046.33	813,014,371.54
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	64,247,000.00	88,554,000.00
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	776,886,075.21	(4,857,439,786.10)
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	14,179,740.25	-
225010	Үнэ төлбөргүй гарсан зардал - Үндсэн хөрөнгө	473,880.00	-
225011	Үнэ төлбөргүй гарсан зардал - Бараа материал	13,705,860.25	-
VII	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (VII)=(IV)-(V)	(14,179,740.25)	-
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(VII)	762,706,334.96	(4,857,439,786.10)

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Код	Дансны нэр, төрөл	Өмнөх он	Тайлант он
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН	25,375,462,331.87	23,719,712,445.32
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1,907,784,378.87	23,719,712,445.32
120	Нийтлэг татварын бус орлого	1,907,784,378.87	1,969,190,002.05
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	1,777,388,416.98	1,947,601,385.00
120004 1	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,777,388,416.98	1,931,249,885.00
120004 2	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	16,351,500.00
120009	Бусад орлого	130,395,961.89	21,588,617.05
122	Тусламжийн орлого	-	21,750,522,443.27
1221	Хандив тусламж /дотоод/	-	21,750,522,443.27
12211	Харьяа төрийн сангаас төсвийн байгууллагад олгосон санхүүжилт, шилжүүлгийн орлого	-	5,299,980,000.00
122111	Урсгал санхүүжилтийн орлого\	-	5,299,980,000.00
122001	Бусад хандив тусламж /дотоод/	-	16,450,542,443.27
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	23,467,677,953.00	-
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	10,974,730,000.00	-
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	9,772,100,000.00	-
131009	Оны эхний үлдэгдлээс санхүүжих	1,202,630,000.00	-
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	14,830,750.00	-
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	14,830,750.00	-
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	12,478,117,203.00	-
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	12,478,117,203.00	-
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	22,765,533,893.66	24,899,031,845.17
21	УРСГАЛ ЗАРДАЛ	22,765,533,893.66	24,899,031,845.17
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	22,534,408,544.19	23,996,370,484.04
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	13,305,104,807.48	14,309,334,123.90
210101	Үндсэн цалин	7,507,420,639.37	6,767,106,514.48
210102	Нэмэгдэл	3,932,535,095.19	5,266,000,350.04
210103	Унаа хоолны хөнгөлөлт	379,816,065.11	964,127,323.93
210104	Урамшуулал	1,485,333,007.81	1,312,099,935.45
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	888,623,308.42	1,585,147,100.00
210201	Тэтгэврийн даатгалын зардал	786,421,641.61	700,000,000.00
210202	Тэтгэмжийн даатгалын зардал	18,345,233.75	450,000,000.00
210203	ҮОМШӨ-ний даатгалын зардал	8,968,016.88	100,000,000.00
210204	Ажилгүйдлийн даатгалын зардал	8,523,951.66	100,000,000.00
210205	Эрүүл мэндийн даатгалын зардал	66,364,464.52	235,147,100.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	531,015,058.08	588,495,186.96
210301	Гэрэл, цахилгаан	272,634,863.23	364,725,057.23
210302	Түлш, халаалт	102,888,565.77	87,567,053.75
210303	Цэвэр, бохир ус	155,491,629.08	136,203,075.98
2104	Хангамж, бараа материалын зардал	387,848,478.23	360,275,612.77
210401	Бичиг хэрэг	27,486,290.00	7,630,100.00
210402	Тээвэр, шатахуун	25,966,000.00	12,490,500.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	33,450,889.22	34,067,701.77
210404	Ном, хэвлэл	8,340,300.00	1,793,250.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	41,624,584.00	44,634,084.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	250,980,415.01	259,659,977.00
2105	Нормативт зардал	5,587,352,638.88	6,312,121,514.78

210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	4,788,877,564.62	5,613,534,412.20
210502	Хоол, хүнс	717,188,273.40	644,390,011.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	81,286,800.86	54,197,091.58
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,247,274,052.10	364,406,880.30
210601	Багаж, техник, хэрэгсэл	812,740,523.40	222,911,935.00
210602	Тавилга	37,740,000.00	-
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	-	6,715,400.00
210604	Урсгал засвар	396,793,528.70	134,779,545.30
2107	Томилолт, зочны зардал	33,624,325.00	69,661,400.00
210701	Гадаад албан томилолт	17,374,325.00	4,000,000.00
210702	Дотоод албан томилолт	14,860,000.00	64,140,000.00
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	1,390,000.00	1,521,400.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	449,561,228.00	314,113,460.33
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	237,575,666.00	191,943,278.33
210803	Даатгалын үйлчилгээ	5,712,000.00	7,639,136.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	329,652.00	1,106,656.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	-	99,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	186,157,800.00	86,402,000.00
210807	Газрын төлбөр	1,448,790.00	1,533,790.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	105,400.00	-
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	18,231,920.00	25,389,600.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	104,004,648.00	92,815,205.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	63,547,560.00	48,955,530.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	40,457,088.00	43,859,675.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	231,125,349.47	902,661,361.13
2132	Бусад урсгал шилжүүлэг	227,605,349.47	901,568,371.54
213202	Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж	5,886,303.14	-
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	155,327,046.33	813,014,371.54
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	66,392,000.00	88,554,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	3,520,000.00	-
213305	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	3,520,000.00	-
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	-	1,092,989.59
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	1,092,989.59
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	2,609,928,438.21	(1,179,319,399.85)
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН	1,419,399,627.79	607,820,262.30
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	1,419,399,627.79	607,820,262.30
2200	Дотоод эх үүсвэрээр	1,419,399,627.79	607,820,262.30
223001	Бусад хөрөнгө	52,996,500.00	80,913,699.30
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	1,366,403,127.79	526,906,563.00
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	(1,419,399,627.79)	(607,820,262.30)
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	1,190,528,810.42	(1,787,139,662.15)
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	716,161,398.76	1,906,690,209.18
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	1,906,690,209.18	119,550,547.03

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Хуримтлагдсан үр дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
1	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	238,499,530.00	39,526,620,230.98	39,765,119,760.98
2	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	238,499,530.00	39,526,620,230.98	39,765,119,760.98
9	Тайлант үеийн үр дүн		762,706,334.96	762,706,334.96
10	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	238,499,530.00	40,289,326,565.94	40,527,826,095.94
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	238,499,530.00	40,289,326,565.94	40,527,826,095.94
19	Тайлант үеийн үр дүн		(4,857,439,786.10)	(4,857,439,786.10)
20	2025 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	238,499,530.00	35,431,886,779.84	35,670,386,309.84

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	1. Төлөвлөгөө	2. Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1	НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	26,942,732,600.00	23,698,123,828.27	(3,244,608,771.73)	88.0
12	Татварын бус орлого	26,942,732,600.00	23,698,123,828.27	(3,244,608,771.73)	88.0
120	Нийтлэг татварын бус орлого	1,942,458,200.00	1,947,601,385.00	5,143,185.00	100.3
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого /үндсэн/	1,926,106,700.00	1,931,249,885.00	5,143,185.00	100.3
120010	Төсөв байгууллагын өөрийн орлого /туслах/	16,351,500.00	16,351,500.00	-	100.0
122	Тусламжийн орлого	25,000,274,400.00	21,750,522,443.27	(3,249,751,956.73)	87.0
122001	Хандив тусламж /дотоод/	19,370,274,400.00	16,450,542,443.27	(2,919,731,956.73)	84.9
122005	Төсвөөс санхүүжих	5,630,000,000.00	5,299,980,000.00	(330,020,000.00)	94.1
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	26,942,732,600.00	25,405,013,418.58	(1,537,719,181.42)	94.3
21	УРСГАЛ ЗАРДАЛ	26,942,732,600.00	25,405,013,418.58	(1,537,719,181.42)	94.3
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	25,490,727,700.00	24,515,067,047.04	(975,660,652.96)	96.2
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	14,605,147,400.00	14,309,334,123.90	(295,813,276.10)	98.0
210101	Үндсэн цалин	6,742,647,400.00	6,767,106,514.48	24,459,114.48	100.4
210102	Нэмэгдэл	5,245,500,000.00	5,266,000,350.04	20,500,350.04	100.4
210103	Унаа хоолны хөнгөлөлт	917,000,000.00	964,127,323.93	47,127,323.93	105.1
210104	Урамшуулал	1,700,000,000.00	1,312,099,935.45	(387,900,064.55)	77.2
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	1,585,147,100.00	1,585,147,100.00	-	100.0
210201	Тэтгэврийн даатгал	700,000,000.00	700,000,000.00	-	100.0
210202	Тэтгэмжийн даатгал	450,000,000.00	450,000,000.00	-	100.0
210203	ҮОМШӨ-ний даатгал	100,000,000.00	100,000,000.00	-	100.0
210204	Ажилгүйдлийн даатгал	100,000,000.00	100,000,000.00	-	100.0
210205	Эрүүл мэндийн даатгал	235,147,100.00	235,147,100.00	-	100.0
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	616,596,600.00	588,495,186.96	(28,101,413.04)	95.4
210301	Гэрэл, цахилгаан	365,827,500.00	364,725,057.23	(1,102,442.77)	99.7
210302	Түлш, халаалт	88,056,800.00	87,567,053.75	(489,746.25)	99.4
210303	Цэвэр, бохир ус	162,712,300.00	136,203,075.98	(26,509,224.02)	83.7
2104	Хангамж, бараа материалын зардал	403,840,700.00	360,275,612.77	(43,565,087.23)	89.2
210401	Бичиг хэрэг	11,367,500.00	7,630,100.00	(3,737,400.00)	67.1
210402	Тээвэр, шатахуун	15,920,600.00	12,490,500.00	(3,430,100.00)	78.5
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	35,312,000.00	34,067,701.77	(1,244,298.23)	96.5

210404	Ном, хэвлэл	1,793,200.00	1,793,250.00	50.00	100.0
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	53,477,000.00	44,634,084.00	(8,842,916.00)	83.5
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	285,970,400.00	259,659,977.00	(26,310,423.00)	90.8
2105	Нормативт зардал	6,770,481,300.00	6,312,121,514.78	(458,359,785.22)	93.2
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	6,000,719,400.00	5,613,534,412.20	(387,184,987.80)	93.5
210502	Хоол, хүнс	713,382,400.00	644,390,011.00	(68,992,389.00)	90.3
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	56,379,500.00	54,197,091.58	(2,182,408.42)	96.1
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,209,323,500.00	882,970,423.30	(326,353,076.70)	73.0
210601	Багаж, техник, хэрэгсэл	788,726,200.00	530,416,235.00	(258,309,965.00)	67.2
210602	Тавилга	29,763,800.00	29,763,800.00	-	100.0
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	7,808,500.00	6,715,400.00	(1,093,100.00)	86.0
210604	Урсгал засвар	383,025,000.00	316,074,988.30	(66,950,011.70)	82.5
2107	Томилолт, зочны зардал	82,879,100.00	69,661,400.00	(13,217,700.00)	84.1
210701	Гадаад албан томилолт	11,510,300.00	4,000,000.00	(7,510,300.00)	34.8
210702	Дотоод албан томилолт	64,457,300.00	64,140,000.00	(317,300.00)	99.5
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	6,911,500.00	1,521,400.00	(5,390,100.00)	22.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	430,512,300.00	322,456,480.33	(108,055,819.67)	74.9
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	194,677,100.00	191,943,278.33	(2,733,821.67)	98.6
210803	Даатгалын үйлчилгээ	10,712,000.00	7,639,136.00	(3,072,864.00)	71.3
210804	Тээврийн хэрэгслийн татвар	1,244,400.00	1,106,656.00	(137,744.00)	88.9
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	422,100.00	99,000.00	(323,100.00)	23.5
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	195,200,000.00	94,745,020.00	(100,454,980.00)	48.5
210807	Газрын төлбөр	1,875,900.00	1,533,790.00	(342,110.00)	81.8
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	281,400.00	-	(281,400.00)	-
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	26,099,400.00	25,389,600.00	(709,800.00)	97.3
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	98,799,700.00	84,605,205.00	(14,194,495.00)	85.6
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	47,480,000.00	40,745,530.00	(6,734,470.00)	85.8
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	51,319,700.00	43,859,675.00	(7,460,025.00)	85.5
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,140,004,900.00	889,946,371.54	(250,058,528.46)	78.1
2132	Бусад урсгал шилжүүлэг	1,140,004,900.00	889,946,371.54	(250,058,528.46)	78.1
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	1,051,004,900.00	813,014,371.54	(237,990,528.46)	77.4
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	89,000,000.00	76,932,000.00	(12,068,000.00)	86.4
8	ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН НИЙТ ТЭНЦЭЛ	-	(1,706,889,590.31)	(1,706,889,590.31)	-
9	АЛДАГДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	-	1,706,889,590.31	1,706,889,590.31	-
7	Харилцах болон хадгаламжийн дансны цэвэр өөрчлөлт	-	1,706,889,590.31	1,706,889,590.31	-
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	1,733,024,251.44	1,733,024,251.44	-
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	26,134,661.13	26,134,661.13	-

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Төрийн тусгай албан хаагчдын нэгдсэн эмнэлэг Засгийн газрын 2016 оны 68 дугаар тогтоолоор Шүүх, прокурор, онцгой байдал, тагнуул, цагдаа, хил хамгаалах, шүүхийн шийдвэр гүйцэтгэх, гааль, шүүхийн шинжилгээний албан хаагчид болон Чингэлтэй дүүргийн иргэдэд эмнэлгийн тусламж, үйлчилгээг үзүүлэх чиг үүрэг бүхий Хууль зүй, дотоод хэргийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллага юм.

Тус эмнэлэг 2025 онд “Төрөөс эрүүл мэндийн талаар баримталж буй бодлого, шийдвэрийг хэрэгжүүлэхэд шинэ технологийг нэвтрүүлж, цахим шинэчлэл, мэргэшсэн хүний нөөцөөр, аюулгүй, ээлтэй орчинд, стандарт шаардлагад нийцүүлэн хүртээмжтэй, тусламж үйлчилгээг иргэдэд үзүүлэхэд оршино” гэсэн зорилгыг дэвшүүлэн тайлант оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг 2025 оны 01 дүгээр сарын 05-ны өдөр баталж, 3 чиглэлээр 6 зорилт 47 арга хэмжээг хэрэгжүүлэхээр тусгаж, гүйцэтгэл 94.4 хувийн биелэлттэй байна.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Төрийн тусгай албан хаагчдын нэгдсэн эмнэлэг үйл ажиллагаандаа Төсвийн тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Эрүүл мэндийн тухай хууль, Эрүүл мэндийн даатгалын тухай хууль, Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний тухай хууль, Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хууль, Төрийн албаны тухай хууль, Цэргийн албаны тухай хууль, Цэргийн албаны эрх зүйн байдлын тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг мөрдөн ажиллаж байна

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг дараах хууль тогтоомж, бодлого чиглэлд өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Төсвийн тухай хуульд төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, хяналт, хариуцлагын тогтолцоог чангатгаж, төсвийн сахилга бат, дунд хугацааны тогтвортой байдлыг хангахад чиглэсэн нэмэлт өөрчлөлтүүд орсон байна. Тухайлбал: төсвийг зохисгүй удирдсанаас авлага, өглөг үүсгэсэн төсвийн захирагчид хариуцлага тооцох эрх зүйн үндсийг тодорхой болгож, дунд хугацааны төсвийн мэдээлэлд хараат бус хяналтыг нэмэгдүүлсэн;
- Сангийн сайдын 2025 оны А/3 дугаар тушаалаар “Төсвийн байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам”-ыг шинэчлэн баталж, төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын нэгдмэл, стандартчилагдсан хэрэгжилтийг хангах эрх зүйн орчныг бүрдүүлсэн;
- Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн А/180 дугаар тушаалаар салбарын Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг шинэчлэн баталсан.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Дотоод аудиторын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Төрийн тусгай албан хаагчдын нэгдсэн эмнэлгийн 2025 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Эмнэлгийн захирлын 2025 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн А/175 дугаар тушаалаар баталсан Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон боловч Сангийн сайдын 2025 оны А/03 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам”-ын дагуу өөрчлөлт оруулаагүй байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн программд Сангийн сайдын 2025 оны А/03 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам”-д нийцүүлэн өөрчилж, сайжруулаагүйгээс Төрийн тусгай албан хаагчдын нэгдсэн эмнэлгийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг тус журмын дагуу бэлтгэн ирүүлээгүй.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 5,553,970.7 мянган төгрөгөөр буюу 13.2 хувиар буурсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	1,906,690.2	119,550.6	(1,787,139.7)
Авлага	5,078,627.6	1,416,138.0	(3,662,489.6)
Бараа материал	4,941,667.8	4,428,708.6	(512,959.2)
Үндсэн хөрөнгө	30,171,240.8	30,579,858.5	408,617.7
Нийт хөрөнгө	42,098,226.4	36,544,255.7	(5,553,970.7)
Өр төлбөр	1,570,400.3	873,869.4	(696,530.9)
Цэвэр хөрөнгө, өмчийн дүн	40,527,826.1	35,670,386.3	(4,857,439.8)
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	42,098,226.4	36,544,255.7	(5,553,970.7)

Тайлант хугацаанд нөлөө бүхий өөрчлөлт гарсан, материаллаг их дүнтэй үлдэгдэл бүхий дараах дансууд байна. Үүнд:

- Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл 119,550.6 мянган төгрөг болж, өмнөх оноос 1,787,139.7 мянган төгрөгөөр буурсан байна. Тус дансанд хөрөнгө оруулалтын барьцааны 93,415.9 мянган төгрөг, урсгал үйл ажиллагаанд зарцуулаагүй 26,134.7 мянган төгрөгийн үлдэгдэлтэй;
- Авлага дансны үлдэгдэл 1,416,138.0 мянган төгрөг болж, тайлант онд Эрүүл мэндийн даатгалын сангаас авах 3,662,489.6 мянган төгрөгийн авлагаар буурсан байна. Тус дансны үлдэгдэлд ахмадын сангийн 1,093.0 мянган төгрөг, MRI аппаратын засвар үйлчилгээний 42,500.0 мянган төгрөг, Эрүүл мэндийн даатгалын гүйцэтгэлийн санхүүжилтийн 1,372,545.0 мянган төгрөгийн авлагууд бүртгэлтэй;
- Бараа материал дансны үлдэгдэл 4,428,708.6 мянган төгрөг болж, тайлант онд төсвийн хөрөнгөөр худалдан авсан 6,555,852.3 мянган төгрөг, хандив тусламжаар хүлээн авсан 40,972.9 мянган төгрөг, үнэ төлбөргүй шилжүүлэн авсан 4,728.4 мянган төгрөг, шинэ төл, нас дэвшүүлсний 2,820.0 мянган төгрөг, шатахууны урамшууллын 984.7 мянган төгрөг, данс хооронд шилжүүлсэн 21,416.9 мянган төгрөгөөр тус тус нэмэгдэж, байгууллагын үйл ажиллагаанд зарцуулсан 7,073,730.8 мянган төгрөг, акталсан 42,035.8 мянган төгрөг, данс хооронд шилжүүлсэн бүртгэсэн 21,416.9 мянган төгрөгөөр тус тус хасагдсантай холбоотойгоор өмнөх оноос 512,959.2 мянган төгрөгөөр буурсан;
- Үндсэн хөрөнгө дансны эцсийн үлдэгдэл 30,579,858.5 мянган төгрөг болж, тайлант онд худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу барилга байгууламжийг капиталжуулсан 526,906.6 мянган төгрөг, хандив тусламжаар хүлээн авсан 107,269.8 мянган төгрөг, шилжүүлэн авсан 1,700.4 мянган төгрөг, Хууль зүй, дотоод хэргийн яамнаас балансаас балансад шилжүүлэн авсан 3,767,093.9 мянган төгрөг, ТӨБЗГ-ын 2025 оны “Үндсэн хөрөнгийн ашиглалтын хугацааг сунгах, үнийг шинэчлэн тогтоох

тухай” 818 дугаар тогтоолын дагуу үнийг шинэчлэн тогтоохоор шилжүүлэн бүртгэсэн 802,567.6 мянган төгрөг, данс хооронд шилжүүлэн залруулж, бүртгэсэн 2,332,345.7 мянган төгрөгөөр тус тус нэмэгдэж, ТӨБЗГ-ын 2025 оны “Үндсэн хөрөнгийн ашиглалтын хугацааг сунгах, үнийг шинэчлэн тогтоох тухай” 818 дугаар тогтоолын дагуу балансын үнэ бүхий хөрөнгийн үнийг шинэчлэн тогтоосон 1,605,135.3 мянган төгрөг, данс хооронд шилжүүлэн залруулж, бүртгэсэн 2,332,345.7 мянган төгрөг, акталж, данснаас хассан 3,421,624.8 мянган төгрөгөөр тус тус хасагдаж, өмнөх оноос 408,617.7 мянган төгрөгөөр буурсан;

- Өр төлбөр дансны үлдэгдэл 873,869.4 мянган төгрөг болж, өмнөх оноос 696,530.9 мянган төгрөгөөр буурсан байна. Тус дансанд Чингэлтэй дүүргийн татварын хэлтэстэй тооцоо нийлж, цалингаас суутгасан ХХОАТ-ын 181,439.3 мянган төгрөг, нийлүүлэгч байгууллагуудад өгөх эм, эмнэлгийн хэрэгслийн үнэ 599,014.1 мянган төгрөг, хөрөнгө оруулалтын барьцааны 93,415.9 мянган төгрөгийн өр төлбөрүүд бүртгэлтэй;
- Программ хангамж дансанд 338,374.0 мянган төгрөгийн анхны өртөгтэй, 279,625.7 мянган төгрөгийн хуримтлагдсан элэгдэлтэй, 58,748.4 мянган төгрөгийн үлдэх өртөгтэй 23 нэр төрлийн программ бүртгэлтэй байна. Тайлант онд урсгал зардлын төсвөөс программын төлбөр, лицензийн төлбөрт 94,836.0 мянган төгрөгийг зарцуулсан;

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2025 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвийн санхүүжилтээр 16,471,300.0 мянган төгрөг, эрүүл мэндийн даатгалын сангийн санхүүжилтээр 11,699,393.3 мянган төгрөг, үндсэн үйл ажиллагааны орлогоор 1,454,106.7 мянган төгрөгийг тус тус бүрдүүлж, нийт зарлагыг 29,624,853.4 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төслөөс эд хогшил, урсгал засварын зардлыг 5,449,913.9 мянган төгрөгөөр нэмэгдүүлж, цалин, хөлс болон нэмэгдэл урамшууллын зардлыг 652,669.7 мянган төгрөгөөр, нормативт зардлыг 412,815.7 мянган төгрөгөөр, ажил олгогчоос төлөх нийгмийн даатгалын шимтгэлийн зардлыг 121,126.9 мянган төгрөгөөр, урсгал шилжүүлгийг 49,161.1 мянган төгрөгөөр, байр ашиглалттай холбоотой тогтмол зардлыг 36,621.6 мянган төгрөгөөр, бусдаар гүйцэтгүүлэх ажил үйлчилгээний зардлыг 31,400.6 мянган төгрөгөөр, хангамж бараа материалын зардлыг 29,559.8 мянган төгрөгөөр, бараа үйлчилгээний зардлыг 6,362.1 мянган төгрөгөөр, томилолт, зочин төлөөлөгч хүлээн авах зардлыг 2,947.9 мянган төгрөгөөр тус тус бууруулж, нийт зардлыг 26,319,145.4 мянган төгрөгөөр баталсан байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийг 5,321,625.9 мянган төгрөгөөр нэмэгдүүлэн тодотгосон бөгөөд төсөв захирагчийн 1 хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлэх 4 арга хэмжээг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвийн санхүүжилтээр 5,630,000.0 мянган төгрөг, оны эхний үлдэгдлээс 4,993,274.5 мянган төгрөг, үйл ажиллагааны орлогоор 1,926,106.7 мянган төгрөг, туслах үйл ажиллагааны орлогоор 16,351.5 мянган төгрөг, Эрүүл мэндийн даатгалын сангаас 14,376,999.9 мянган төгрөгөөр тус тус бүрдүүлэхээр баталсан байна.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 5,299,980.0 мянган төгрөгийн санхүүжилт авч, үйл ажиллагааны орлогоор 1,931,249.9 мянган төгрөг, туслах үйл ажиллагааны орлогоор 16,351.5 мянган төгрөг, оны эхний үлдэгдлээс 4,988,675.8 мянган төгрөг, Эрүүл мэндийн даатгалын сангаас 11,461,866.7 мянган төгрөгийн орлогыг тус тус бүрдүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 25,405,013.4 мянган төгрөг буюу 94.3 хувьтай байгаа нь Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих санхүүжилтийг 1,194,702.5 мянган төгрөг,

ажил олгогчоос олгох тэтгэмж, урамшууллын зардлыг 250,058.5 мянган төгрөгөөр дутуу зарцуулсантай холбоотой байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөгөөр/					
Код	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт %/I
71602	Эмнэлгийн тусламж үйлчилгээ	26,942,732.6	25,405,013.4	(1,537,719.2)	94.3
80101	Үндсэн үйл ажиллагааны зардал	4,489,995.1	4,401,261.0	(88,734.1)	98.0
80802	Ажил олгогчоос олгох тэтгэмж, урамшуулал	1,140,004.9	889,946.4	(250,058.5)	78.1
81613	ЭМД-ын сангаас санхүүжих	21,296,381.1	20,101,678.6	(1,194,702.5)	94.4
83604	Нэмэлт-Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	16,351.5	12,127.5	(4,224.0)	74.2

Монгол Улсын Ерөнхий аудиторовын баталсан “Санхүүгийн аудитад баримтлах ерөнхий чиглэл”-ийн дагуу судалгааг авч, дүн шинжилгээ хийж үзэхэд дараах байдалтай байна. Үүнд:

- Төрийн тусгай албан хаагчдын нэгдсэн эмнэлгийн бүтэц, орон тоо, цэргийн алба хаагчийн албан тушаалын ангилал, цэргийн цолны зэрэглэлийг Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2025 оны 4 дугаар сарын 18-ны өдрийн МН/122 дугаар тушаалаар шинэчлэн баталсан тул тус асуудлыг тулган баталгаажуулах боломжгүй;
- Унаа, хоолны хөнгөлөлтийн зардлыг эмнэлгийн захирлын “Хоолны хөнгөлөлтийг нэмэгдүүлэн олгох тухай” 2025 оны А/09 дүгээр тушаалаар нэг хүнд хоол 9.0 мянган төгрөг, унаа 1.0 мянган төгрөг байхаар баталсан байна. Төлөвлөгөөнд нийт 917,000.0 мянган төгрөгөөр батлагдаж, 964,127.3 мянган төгрөгийн гүйцэтгэлтэй;
- Гадаад томилолтын 1 арга хэмжээнд 11,510.3 мянган төгрөгийн төсөв баталж, гүйцэтгэлээр ХЗДХС-ын ОХУ-д хийх айлчлал мөн ХБНГУ-д эмч нарын олон улсын хурал, сургалтад хамрагдахад нийт 16,510.3 мянган төгрөгийн зардал гаргасан;
- Тайлант онд сургалт, семинар, хурал, зөвлөгөө, хэвлэл мэдээллийн байгууллагуудтай байгуулсан ажил, үйлчилгээний гэрээ, төлбөр, төрд учирсан хохирлыг барагдуулахтай холбоотой зардал гараагүй;

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.5.4 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Төрийн тусгай албан хаагчийн нэгдсэн эмнэлэг нь ХЗДХС-ын 2025 оны А/08 дугаар тушаалаар баталсан “Худалдан авах ажиллагааны 2025 оны төлөвлөгөө”-нд нийт 8,223,592.1 мянган төгрөгийн 16 нэр төрлийн бараа, ажил, үйлчилгээг нээлттэй тендер шалгаруулалтын аргаар 7, харьцуулалтын аргаар 4, шууд худалдан авалтын аргаар 5 худалдан авах ажиллагааг зохион байгуулахаар төлөвлөж, баталсан төлөвлөгөөний дагуу зохион байгуулсан байна.

Тус төлөвлөгөөг тайлант оны 6 дугаар сард ХЗДХС-ын 2025 оны А/239 дугаар тушаалаар 1,206,850.0 мянган төгрөгөөр нэмж, 9,430,442.1 мянган төгрөг болгон тодотгосон байна. Гүйцэтгэлээр нийт 5,768,669.8 мянган төгрөгийн төсөвт өртөгтэй, бараа, ажил үйлчилгээг нээлттэй тендер шалгаруулалтын аргаар 5,382,938.9 мянган төгрөгийн 9, харьцуулалтын

аргаар 255,746.1 мянган төгрөгийн 6, шууд худалдан авалтын аргаар 81,042.3 мянган төгрөгийн 9, ерөнхий гэрээний аргаар 48,942.5 мянган төгрөгийн 1 худалдан авах ажиллагааг зохион байгуулж, 61.3 хувийн хэрэгжилттэй байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Төрийн тусгай албан хаагчдын нэгдсэн эмнэлгийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийсэн байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулах талаар ЭМДС-аас авах санхүүжилтийн хасагдуулга, өмгөөллийн үйлчилгээ, урьдчилж гарсан зардал, санхүүгийн программ, байгууллагын бүтэц орон тоотой холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Санхүүгийн аудитын газрын аудитор Н.Нямсүрэн гүйцэтгэж, чанарын хяналтыг ахлах аудитор П.Амарсанаа, аудитын менежер Б.Долгорсүрэн, газрын захирал, тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг нар дараагийн шатны хяналтыг тус тус хэрэгжүүлсэн.

Төрийн тусгай албан хаагчдын нэгдсэн эмнэлэг 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Үндэсний аудитын газарт 2026 оны 01 дүгээр сарын 21-ний өдрийн 49 дүгээр албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2024 оны жилийн эцсийн санхүүгийн үр дүнгийн тайлан, суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “Дунд” гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2024 оны жилийн эцсийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 26,629,357.5 мянган төгрөгийн 1 хувиар буюу 266,293.6 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагатай гэж үзсэн.

Санхүүгийн үр дүнгийн тайлангийн 2025 оны жилийн эцэст нийт зардал 29,664,715.1 мянган төгрөг болж, 3,035,357.6 мянган төгрөгөөр өссөн тул гүйцэтгэлийн материаллаг байдлын суурь, хувь хэмжээг өөрчлөхгүйгээр материаллаг байдлыг 296,647.2 мянган төгрөгөөр шинэчлэн тогтоолоо.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор байгууллага сургалт, семинар, хурал, зөвлөгөөнийг цахимаар хийж, хэвлэл мэдээллийн байгууллагуудтай ажил, үйлчилгээний гэрээ байгуулаагүй байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

Нийцлийн асуудлаар нийт 2 зөрчил илэрсэнд алдаа зөрчлийг арилгаж, давтан гаргахгүй байх 2 зөвлөмж өгөв.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант онд шилэн дансны мэдээллийн цахим системд 5 саяас дээш үнийн дүн бүхий 23,025,186.6 мянган төгрөгийн 170 орлогын гүйлгээ, 7,792,023.1 мянган төгрөгийн 465 зарлагын гүйлгээ, нийт 30,817,209.7 мянган төгрөгийн 635 мэдээллийг бүрэн байршуулсан байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Зөвлөмж

1. Бүтэц, орон тоо, цэргийн алба хаагчийн албан тушаалын ангилал, цэргийн цолны зэрэглэлтэй холбоотой.

Илрүүлэлт: Эмнэлгийн бүтэц, орон тоо, цэргийн алба хаагчийн албан тушаалын ангилал, цэргийн цолны зэрэглэлийг Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2025 оны 4 дүгээр сарын 18-ны өдрийн МН/122 дугаар тушаалаар шинэчлэн баталсан тул тус асуудлыг тулган баталгаажуулах боломжгүй байна. ХЗДХС-ын 2023 оны А/346 дугаар тушаалаар баталсан “Албаны нууцад хамаарах мэдээллийн жагсаалт”, Эмнэлгийн захирлын 2024 оны А/49 дүгээр тушаалаар баталсан “Албаны нууцад хамаарах мэдээллийн жагсаалт”-д тус эмнэлгийн бүтэц, орон тоо, цэргийн алба хаагчийн албан тушаалын ангилал, цэргийн цолны зэрэглэлийг хамруулаагүй байна.

Энэ нь Төрийн болон албаны нууцын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1-т “Албаны нууцад хамаарах мэдээллийн жагсаалтыг тухайн хариуцсан байгууллага боловсруулж, асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн, байгууллагын даргын шийдвэрээр батална”, 16 дугаар зүйлийн 16.3-т “Төрийн болон албаны нууцад хамаарах мэдээлэлд энэ хуульд зааснаас өөр нууцын зэрэглэл хэрэглэхийг хориглоно” гэж заасантай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Төрийн болон албаны нууцын тухай хуульд заасны дагуу төрийн болон албаны нууцад хамаарах мэдээллийн жагсаалтыг хуульд нийцүүлэн баталж, мөрдөж, ажиллах.

2. Санхүүгийн программтай холбоотой асуудал

Илрүүлэлт: Төрийн тусгай албан хаагчдын нэгдсэн эмнэлгийн төсөв, санхүүгийн үйл ажиллагаа, бүртгэлээр тавих дотоод хяналт, тайлан, бүртгэлийг хөтөлдөг Юникус программ Сангийн сайдын 2025 оны А/03 дугаар тушаалаар баталсан “Төсвийн байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам”-ын дагуу сайжруулалт хийгдээгүй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-т “Аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлийн дараах зарчмыг баримтална”, 5.1.4-т “үнэн зөв байх” гэж заасантай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Эмнэлгийн төсөв, санхүүгийн үйл ажиллагаа, бүртгэлээр тавих дотоод хяналт, тайлан, бүртгэл хөтөлдөг программд хөгжүүлэлт хийж, санхүүгийн тайланг Сангийн сайдын 2025 оны А/03 дугаар тушаалаар баталсан журамд нийцүүлэн тайлагнах.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн бусад хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй гэж дүгнэлээ.

4.5 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх аудитаар 89,956.9 мянган төгрөгийн зөрчил илэрсэнд 281.0 мянган төгрөгийн 1 төлбөрийн акт тогтоож, зөрчлийг арилгуулахаар 70,315.0 мянган төгрөгийн 3 албан шаардлага, 19,360.9 мянган төгрөгийн 5 зөвлөмж өгсөн байна.

Аудитын шийдвэрийг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг Төрийн аудитын байгууллагад 2025 оны 03 дугаар сарын 21-ний өдрийн 262 дугаар албан бичгээр, биелэлтийн тайлан, нотлох баримтыг 2025 оны 06 дугаар сарын 19-ний өдрийн 702 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

Аудитын шийдвэрийн хэрэгжилтийг ирүүлсэн нотлох баримтад тулгуурлан үнэлэхэд 100.0 хувь хэрэгжүүлсэн байна.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Төлбөрийн акт	1	281.0	1	281.0	100.0
Албан шаардлага	3	70,315.0	3	70,315.0	100.0
Зөвлөмж	5	19,360.9	5	19,360.9	100.0
Нийт дүн	9	89,956.9	9	89,956.9	100.0

/мянган төгрөгөөр/

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

- Төрийн тусгай албан хаагчдын нэгдсэн эмнэлгийн төсөв, санхүүгийн үйл ажиллагаа, бүртгэлээр тавих дотоод хяналт, тайлан, бүртгэлийг хөтөлдөг Юникус программ Сангийн сайдын 2025 оны А/3 дугаар тушаалаар баталсан "Төсвийн байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам"-ын дагуу сайжруулалт хийсэн эсэх,
- Эмнэлгийн үйл ажиллагаанд ашигладаг эрүүл мэндийн программ нийлүүлэгч 2 компанид байгаа өвчтөний түүх, эмзэг мэдээлэл, төрийн болон албаны нууц мэдээллүүд алдагдахгүй байх талаар баталгаажуулалт хийсэн мөн нэмэлт зардал гарсан эсэхийг үзэх.

Дараагийн шатны аудитаар дахаар 2 асуудлыг авч үзэхээр шийдвэрлэлээ.

- Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2025 оны Б/26 дугаар тушаалаар цэргийн алба хаах насны хязгаарт хүрч, өндөр насны тэтгэвэрт тогтоолгон, төрийн жинхэнэ албаны нөөцөд байгаа иргэнийг түр орлон гүйцэтгэгчээр томилж, үндсэн цалинг нэмэгдлийн хамт тооцож, олгох шийдвэр гаргаж, 3,541.3 мянган төгрөгийн цолны болон онцгой нөхцөлийн нэмэгдэл олгосон байна. Энэ нь Төрийн албаны тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.2.3-т "Төрийн алба хаах насны дээд хязгаарт хүрсэн", 57 дугаар зүйлийн 57.1-т "Төрийн албан хаагчид хууль болон албан тушаалын тодорхойлолтод заасан чиг үүргээ хэрэгжүүлсний төлөө төрөөс цалин хөлс олгоно", Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 16 дугаар зүйлийн 16.5.5-д "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", Цэргийн алба хаагчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1-д "Хуульд заасан чиг үүргээ хэрэгжүүлсний төлөө цэргийн алба хаагчид цалин хөлс олгоно", 9.2-т "Цэргийн алба хаагчийн цалин хөлс нь үндсэн ба цэргийн цолны цалингаас ... бүрдэнэ", Засгийн газрын 2019 оны "Журам батлах тухай" 9 дүгээр тогтоолын хавсралтын 2.3-д "Төрийн албаны тухай хуулийн 43.3.4-т заасан үндэслэлээр төрийн албан хаагчийн нөөцөд бүртгэгдсэн иргэнийг сонгон авч түр орлон гүйцэтгүүлсэн бол тухайн албан тушаалын цалинг түүнд олгоно" гэж заасныг зөрчсөн асуудлыг дараагийн шатны аудитаар авч үзэхээр болов.
- Хууль зүй, дотоод хэргийн яаманд сэлгэн ажиллаж байгаа Санхүү, хөрөнгө оруулалтын газрын даргад Төрийн тусгай албан хаагчийн нэгдсэн эмнэлгээс 6,948.2 мянган төгрөгийн цолны нэмэгдэл олгосон нь ТТ-11 Цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлого, шууд бус орлогод ногдуулан суутгасан албан татварын тайлангаар нотлогдож байна. Энэ нь

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-т "Аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлийн дараах зарчмыг баримтална" 5.1.4-т "үнэн зөв байх", Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.3-т "төсвийн гүйцэтгэлийг хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлж, тайлагнах", Төрийн албаны тухай хуулийн 57 дугаар зүйлийн 57.1-т "Төрийн албан хаагчид хууль болон албан тушаалын тодорхойлолтод заасан чиг үүргээ хэрэгжүүлсний төлөө төрөөс цалин хөлс олгоно", Цэргийн алба хаагчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.2-т "Цэргийн алба хаагчийн цалин хөлс нь үндсэн ба цэргийн цолны цалингаас гадна доор дурдсан нэмэгдлээс бүрдэнэ", 9.2.1-д "байлдааны жижүүрлэлтийн болон тусгай үүргийн", 9.2.2-т "төрийн тусгай алба хаасан хугацааны", 9.2.3-т "онцгой нөхцөлийн", 9.2.4-т "цэргийн мэргэжлийн зэргийн", 9.2.5-д "хилийн", 9.2.6-д "төрийн нууцад хамаарах мэдээ мэдээлэл хариуцсаны", 9.2.7-д "боловсролын болон эрдмийн зэрэг, цолны", 9.6-д "Цэргийн алба хаагчид хууль тогтоомжид заасан бусад нэмэгдэл, урамшууллыг олгож болно", Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга, Төрийн албаны зөвлөлийн даргын хамтарсан 34/31 дугаар "Журам батлах тухай" тушаалын 3.5-д "Сэлгэн ажиллуулах албан хаагчийг анх илгээсэн байгууллага болон сэлгэн ажиллуулж байгаа байгууллага хооронд гэрээ байгуулна. Гэрээнд ... цалин хөлс, орон байрны болон бусад зардал, хүлээх хариуцлага, ажлын эцсийн үр дүнг ... албан хаагч гарын үсэг зурж баталгаажуулна", 5.2-т "Төрийн жинхэнэ албан хаагчийг шилжүүлэх, сэлгэн ажиллуулахад тухайн албан хаагчийн ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг шилжүүлж, сэлгэн ажиллуулж байгаа байгууллага хариуцна. Тухайн албан хаагчийн нийгмийн баталгааг анх илгээсэн төрийн байгууллагад ажиллаж байсан нөхцөлөөс дордуулахгүй", ХЗДХЯ төрийн жинхэнэ албан хаагчийн төрийн байгууллага хооронд сэлгэн ажиллуулах гэрээний 4.1-т "Төрийн албаны тухай хуулийн 44 дүгээр зүйлийн сарын үндсэн цалинг 2,218.0 мянган төгрөгөөр тогтоож, зэрэг, дэв, төрийн алба хаасан хугацааны нэмэгдэл, хоол, унааны хөнгөлөлтийг ажил олгогч байгууллагын хөдөлмөрийн дотоод журамдолгоно" гэж заасныг тус тус зөрчсөн байгааг анхаарч үзэх.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 207,116.8 мянган төгрөгийн 5 зөрчил¹ илэрсэнд, зөрчлийг таслан зогсоох 58,001.9 мянган төгрөгийн 3 албан шаардлага хүргүүлж, 149,114.9 мянган төгрөгийн 3 зөвлөмж өгч, 35,800.0 мянган төгрөгийн 1 асуудлыг хууль хяналтын байгууллагад шилжүүллээ.

Нийт илрүүлсэн 214,065.1 мянган төгрөгийн залруулагдаагүй зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс даваагүй боловч шинж чанарын хувьд материаллаг тул “Хязгаарлалттай” дүгнэлт өгсөн.

5.1 Албан шаардлага

Илрүүлэлт 1. Хууль зүй, дотоод хэргийн сайдын ОХУ-д айлчлах айлчлалын бүрэлдэхүүнд багтсан албан хаагчид гадаад албан томилолтын зардалд Захирлын 2025 оны Б/08 дугаар тушаалаар 10,938.9 мянган төгрөг, илтгэх урлагийн сургалтад 1,000.0 мянган төгрөгийг олгож, төсвийг үр ашиггүй зарцуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-т "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 16 дугаар зүйлийн 16.5.5-д "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", 41 дүгээр зүйлийн 41.2.3-т "төсвийн гүйцэтгэлийг хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлж, тайлагнах" гэж заасныг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулаагүй зөрчлийг таслан зогсоож, давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллах албан шаардлага хүргүүлэв.

Илрүүлэлт 2: Тайлант онд цахим программ ашиглуулах, хөгжүүлэлт хийлгэх 49,700.0 мянган төгрөгийн ТТАХНЭ/2025020101 дугаар гэрээг байгуулж, хугацааг 2 удаа сунгасан боловч гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй, тус программын хөгжүүлэлт бүрэн хийгдээгүйгээс шалтгаалан цаашид ашиглахыг зогсоосноос 35,800.0 мянган төгрөгийг үр ашиггүй зардалд зарцуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-т "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 16 дугаар зүйлийн 16.1-т "Төсвийн байгууллага нь түүний үйл ажиллагааг үр ашигтай удирдлагаар хангаж, ажлын үр дүнг хариуцах үүрэг бүхий төсвийн шууд захирагчтай байна" гэж заасныг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: 1. Эмнэлгийн үйл ажиллагаанд зөвшөөрөлгүй, бүрэн хөгжүүлэлт хийгээгүй, программ хангамжийг нэвтрүүлсэн, гэрээний үүргийн биелэлтэд хяналт тавьж, ажлыг бүрэн дуусгаагүй зөрчлийг таслан зогсоож, давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллах албан шаардлага хүргүүлэв.

Илрүүлэлт 3: И-клиник программыг нэвтрүүлэхдээ 10,263.0 мянган төгрөгийн сервер түрээсийн үйлчилгээний хөлс төлж, үр ашиггүй зардал гаргасан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-т "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 16 дугаар зүйлийн 16.5.2-т "батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих", 16.5.5-д "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах" гэж заасныг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Сервер түрээсийн үйлчилгээний хөлс төлж, үр ашиггүй зардал гаргасан зөрчлийг таслан зогсоож, давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллах албан шаардлага хүргүүлэв.

5.2 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

¹ Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

1. Эрүүл мэндийн даатгалын сангаас авах санхүүжилттэй холбоотой асуудал

Илрүүлэлт 1. Тайлант онд ЭМДС-аас нэхэмжилсэн авлагын дүнгээс 795,239.1 мянган төгрөгийг хасагдуулан тооцсон нь өмнөх оноос 20.0 хувь буюу 132,414.9 мянган төгрөгөөр өссөн байна. Нийт хасагдлын 77.8 хувь буюу 619,012.3 мянган төгрөг нь сүүлийн 6 сарын хугацаанд эмнэлгийн программ хангамжийн шинэчлэлтэй холбоотой үүссэн байна. Хоёр программ шилжихэд цаасаар өвчтөний түүх хөтөлсөн, эмч нарын оруулсан мэдээлэл алдаатай шивэгдсэн, цахим хасагдал зэргээс шалтгаалан өссөн байна. Цаашид эмнэлгийн программ хангамжийг сольж, шинэчлэхдээ тагнуулын байгууллагын зөвшөөрөлтэй программ хангамж мөн эсэхийг нягталж, өвчтөний эмзэг мэдээлэл алдагдах, өвчний түүх устах, байгууллагын хэвийн үйл ажиллагаанд саад учруулахгүй байх тал дээр анхаарч ажиллах шаардлагатай байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-т "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 16 дугаар зүйлийн 16.1-т "Төсвийн байгууллага нь түүний үйл ажиллагааг үр ашигтай удирдлагаар хангаж, ажлын үр дүнг хариуцах үүрэг бүхий төсвийн шууд захирагчтай байна", 16.5.5-д "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Эрүүл мэндийн даатгалын сангаас авах санхүүжилтийн хасагдлыг 20 хувь хүртэл бууруулж, ажиллах.

2. Зардлын данстай холбоотой асуудал

Илрүүлэлт 2. Өмгөөллийн фермд 15,000.0 мянган төгрөг, иргэн А-д 1,700.0 мянган төгрөг, нийт 16,700.0 мянган төгрөгийг хууль, өмгөөллийн үйлчилгээнд зарцуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-т "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 16 дугаар зүйлийн 16.5.5-д "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах" гэж заасантай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Байгууллагын бүтцэд байгаа орон тооны ажилтнаар ажлын байрны тодорхойлолтод заасан чиг үүргийг хэрэгжүүлж, нэмэлт зардал гаргахгүй ажиллах.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

№	Нийт зөрчил		Үүнээс						Хууль хяналтын байгууллагад шилжүүлэх	
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Тоо	Дүн
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн		
Тайлант онд ЭМДС-аас нэхэмжилсэн авлагын дүнгээс 795,239.1 мянган төгрөгийг хасагдуулан тооцсон нь өмнөх оноос 20.0 хувь буюу 132,414.9 мянган төгрөгөөр өссөн байна. Нийт хасагдал 77.8 хувь буюу 619,012.3 мянган төгрөг нь сүүлийн 6 сарын хугацаанд эмнэлгийн программ хангамжийн шинэчлэлтэй холбоотой үүссэн байна. Хоёр программ шилжихэд цаасаар өвчтөний түүх хөтөлсөн, эмч нарын оруулсан мэдээлэл алдаатай шивэгдсэн, цахим хасагдал зэргээс шалтгаалан өссөн байна. Цаашид эмнэлгийн программ хангамжийг сольж, шинэчлэхдээ тагнуулын байгууллагын зөвшөөрөлтэй программ хангамж мөн эсэхийг нягталж, өвчтөний эмзэг мэдээлэл алдагдах, өвчний түүх устах, байгууллагын хэвийн үйл ажиллагаанд саад учруулахгүй байх тал дээр анхаарч ажиллах шаардлагатай байна.	1	132,414.9					1	132,414.9		
Өмгөөллийн фермд 15,000.0 мянган төгрөг, иргэн Аззаяад 1,700.0 мянган төгрөг, нийт 16,700.0 мянган төгрөгийг хууль, өмгөөллийн үйлчилгээнд зарцуулсан байна.	1	16,700.0					1	16,700.0		
Хууль зүй, дотоод хэргийн сайдын ОХУ-д айлчлах айлчлалын бүрэлдэхүүнд багтсан албан хаагчид гадаад албан томилолтын зардалд захирлын 2025 оны Б/08 дугаар тушаалаар 10,938,928.00 /Арван сая есөн зуун гучин найман мянган есөн зуун хорин найман/ төгрөг, илтгэх урлагийн сургалтад 1,000,000.00 /Нэг сая/ төгрөгийг олгож, батлагдсан төсвийг үр ашиггүй зарцуулсан байна.	1	11,938.9			1	11,938.9				

Тайлант онд цахим программ ашиглуулах, хөгжүүлэлт хийлгэх 49,700,000.00 /Дөчин есөн сая долоон зуун мянган/ төгрөгийн ТТАХНЭ/20250201017 дугаар гэрээг байгуулж, хугацааг 2 удаа сунгасан боловч ашиглалтад бүрэн шилжүүлж аваагүй, үйл ажиллагаанд ашиглахаа больж, 35,800,000.00 /Гучин таван сая найман зуун мянган/ төгрөгийг үр ашиггүй зардалд зарцуулсан байна.	1	35,800.0			1	35,800.0			1	35,800.0
И-клиник программыг нэвтрүүлэхдээ ... ХХК-д 10,263,000.00 /Арван сая хоёр зуун жаран гурван мянган/ төгрөгийн сервер түрээсийн үйлчилгээний хөлс төлж, үр ашиггүй зардал гаргасан байна	1	10,263.0			1	10,263.0				
НИЙТ	5	207,116.8	0	-	3	58,001.9	2	149,114.9	1	35,800.0

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Төрийн тусгай албан хаагчдын нэгдсэн эмнэлгийн төсөв, санхүүгийн үйл ажиллагаа, бүртгэлээр тавих дотоод хяналт, тайлан, бүртгэлийг хөтөлдөг Юникус программ Сангийн сайдын 2025 оны А/3 дугаар тушаалаар баталсан "Төсвийн байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам"-ын дагуу сайжруулалт хийгдээгүй байна.	1	-					1	-
ТТАХНЭ-ийн бүтэц, орон тоо, цэргийн алба хаагчийн албан тушаалын ангилал, цэргийн цолны зэрэглэлийг Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2025 оны 4 дугаар сарын 18-ны өдрийн МН/122 дугаар тушаалаар шинэчлэн баталсан тул тус асуудлыг тулган баталгаажуулах боломжгүй байна. Тус эмнэлгийн захирлын 2024 оны А/49 дүгээр тушаалаар баталсан "Албаны нууцад хамаарах мэдээллийн жагсаалт"-д бүтэц, орон тоо, цэргийн алба хаагчийн албан тушаалын ангилал, цэргийн цолны зэрэглэлийг хамруулаагүй, нээлттэй мэдээлэлд МАШ НУУЦ тамга дарж, нууцалсан нь холбогдох хууль тогтоомжид нийцэхгүй байна.	1	-					1	-
НИЙТ	2	-					2	-



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 02 сарын 25 өдөр

Дугаар 174/А0170083

Улаанбаатар хот

САГ-2026-217/НА-СТА-ТМ3

Зөрчил таслан зогсоох тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Төрийн тусгай албан хаагчдын нэгдсэн эмнэлгийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ.

И-клиник программыг нэвтрүүлэхдээ Айтүүлс ХХК-д 10,263,000.00 /Арван сая хоёр зуун жаран гурван мянган/ төгрөгийн сервер түрээсийн үйлчилгээний хөлс төлж, үр ашиггүй зардал гаргасан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-т "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 16 дугаар зүйлийн 16.5.2-т "батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих;" 16.5.5-д "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах" гэж заасныг тус тус зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.4-т "төсвийн хөрөнгийг үр ашиггүй зарцуулсан, зах зээлийн үнээс өндөр үнэтэй эсвэл шаардлагагүй хөрөнгө олж бэлтгэсэн" гэж заасныг тус тус үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Сервер түрээсийн үйлчилгээний хөлс төлж, үр ашиггүй зардал гаргасан зөрчлийг таслан зогсоож, биелэлтийн тайлан нотлох баримтыг 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Төрийн тусгай албан хаагчдын нэгдсэн эмнэлгийн Захирлын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (Т.Нарантуяа), Санхүү хангамжийн албаны дарга, ахмад (М.Мөнхбаяр) нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
АХЛАХ АУДИТОР
АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ
Б.ДОЛГОРСҮРЭН
П.АМАРСАНАА
Н.НЯМСҮРЭН





ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 02 сарын 25 өдөр

Дугаар 173/А0140083

Улаанбаатар хот

САГ-2026/017/НА-СТА-ТМ5

Зөрчил таслан зогсоох тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Төрийн тусгай албан хаагчдын нэгдсэн эмнэлгийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ.

Тайлант онд И Клиник ХХК-тай цахим программ нийлүүлэн, хөгжүүлэлт хийлгэх 49,700,000.00 /Дөчин есөн сая долоон зуун мянган/ төгрөгийн ТТАХНЭ/20250201017 дугаар гэрээг байгуулж, хугацааг 2 удаа сунгасан боловч гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүйгээс тус программын хөгжүүлэлт бүрэн хийгдээгүйгээс шалтгаалан цаашид ашиглахыг зогсоосноос 35,800,000.00 /Гучин таван сая найман зуун мянган/ төгрөгийг үр ашиггүй зардалд зарцуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-т "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 16 дугаар зүйлийн 16.1-т "Төсвийн байгууллага нь түүний үйл ажиллагааг үр ашигтай удирдлагаар хангаж, ажлын үр дүнг хариуцах үүрэг бүхий төсвийн шууд захирагчтай байна" гэж заасныг тус тус зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.4-т "төсвийн хөрөнгийг үр ашиггүй зарцуулсан, зах зээлийн үнээс өндөр үнэтэй эсвэл шаардлагагүй хөрөнгө олж бэлтгэсэн" гэж заасныг тус тус үндэслэн **ШААРДАХ** нь:

1. Эмнэлгийн үйл ажиллагаанд зөвшөөрөлгүй, бүрэн хөгжүүлэлт хийгээгүй, программ хангамж нэвтрүүлж, гэрээний үүргийн биелэлтэд хяналт тавьж, ажлыг бүрэн дуусгаагүй зөрчлийг таслан зогсоож, биелэлтийн тайлан, нотлох баримтыг 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Төрийн тусгай албан хаагчдын нэгдсэн эмнэлгийн Захирлын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (Т.Нарантуяа), Санхүү хангамжийн албаны дарга, ахмад (М.Мөнхбаяр) нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
АХЛАХ АУДИТОР
АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ
Б.ДОЛГОРСҮРЭН
П.АМАРСАНАА
Н.НЯМСҮРЭН



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 02 сарын 25 өдөр

Дугаар 172/АО 170083

Улаанбаатар хот

САГ-2026/214/НА-СТА-ТШС

Зөрчил таслан зогсоох тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Төрийн тусгай албан хаагчдын нэгдсэн эмнэлгийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

ОХУ-д айлчлах айлчлалын бүрэлдэхүүнд багтсан албан хаагчид гадаад албан томилолтын зардалд захирлын 2025 оны Б/08 дугаар тушаалаар 10,938,928.00 /Арван сая есөн зуун гучин найман мянган есөн зуун хорин найман/ төгрөг, илтгэх урлагийн сургалтад 1,000,000.00 /Нэг сая/ төгрөгийг олгож, батлагдсан төсвийг үр ашиггүй зарцуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-т "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 16 дугаар зүйлийн 16.5.5-д "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", 41 дүгээр зүйлийн 41.2.3-т "төсвийн гүйцэтгэлийг хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлж, тайлагнах" гэж заасныг тус тус зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.6-д "төсвийг зориулалт бусаар зарцуулсан" гэж заасныг тус тус үндэслэн **ШААРДАХ** нь:

1. Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулаагүй зөрчлийг таслан зогсоож, биелэлтийн тайлан, нотлох баримтыг 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Төрийн тусгай албан хаагчдын нэгдсэн эмнэлгийн Захирлын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч /Л.Нарантуяа/, Санхүү хангамжийн албаны дарга, ахмад /М.Мөнхбаяр/ нарт даалгаж.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
АХЛАХ АУДИТОР
АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ
Б.ДОЛГОРСҮРЭН
Я.АМАРСАНАА
Н.НЯМСҮРЭН